



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 23 эдэр

Дугаар 10

Баруун-Урт

Г

“Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан
сэргийлэх чиглэлээр хийх үйл ажиллагааны
дэд хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн “Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбэрийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Хот байгуулалт, дэд бүтцийн хороо, Аймгийн Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар /Т.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Б.МОНХБАТ

D:My Documents /Тогтоол /

01000018

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 10 сарын 23-ны өдрийн
10... тоот төгтоолын хавсралт



СҮХБААТАР АЙМГИЙН 2018-2020 ОНД ЗАМ
ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015 он/-ийн 9 дүгээр зүйл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл. 7.6 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хууль 63, 64, 65 дугаар зүйл, Жолоочийн даатгалын тухай хууль болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он) зэрэг эрх зүйн баримт, бичгүүд батлагдсанаар замын хөдөлгөөний аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрэлджээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн төлөв байдал:

Тус аймагт 2017 онд Цагдаагийн газарт хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 38, зам тээврийн ослын шинжтэй 82, нийт 120 дуудлага, мэдээлэл бүртгэгдснээс гэмт хэргийн улмаас нас барсан 21, гэмтсэн хүн 24, жолооч үүргээ биелүүлээгүй 1, ослын газрыг орхиж, зугтсан 2 гэмт хэрэг тус тус үйлдэгджээ.

Нийт үйлдэгдсэн гэмт хэрэг, ослыг урьд оны мөн үетэй харьцуулахад дуудлага, мэдээлэл 32 нэгжээр буюу 42,1 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15 нэгжээр буюу 65,2 хувиар, нас барсан хүн 12 нэгжээр буюу 130 хувиар, гэмтсэн хүн 12 нэгжээр буюу 100 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж замын хяналт шалгалтаар 4262 зөрчил илрүүлж ажиллаа. Үнд: согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 389 зөрчлийг илрүүлэн ЗХАБТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1, ЗХ-ийн 14.7.3.1-д тус тус зааснаар 350 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, тортосон, эрхийн үнэмлэхгүй буюу эрххасагдсан үедээ, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 39 хүнийг шүүгчийн шийтгэвэрээр 7-14 хоногийн хугацаагаар баривчлуулсан, 6 жолоочийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоон, Цагдаагийн нийтлэг үүргийн дагуу нийт 84 зөрчлийг тус тус илрүүлсэн, ЦБУАЖ-ын /код-411/ дагуу түр saatuuлах үндэслэлээр 596 тээврийн хэрэгслийг түр saatuuлах байранд saatuuулж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм зөрчсөн нийт 4262 хүнд 230,638,000 төгрөгийн тортосон оногдуулж ажилласан байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Аймгийн нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг осол, хэргийг бууруулах, таслан зогсоох, иргэдийн

аюулгүй зорчих, нөхцөл, боломжийг хангахад төр, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан тэдгээрийг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын үр нелөөг дээшлүүлж төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийг сурталчлах, иргэдэд түгээн дэлгэрүүлэх, цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, замын хөдөлгөөнд соёлтой оролцох сэтгэлгээг төлөвшүүлэх
2. Замын хөдөлгөөнийг хянаж, зохицуулах ажилд орчин үеийн дэвшилтээг техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг нэгдсэн сүлжээнд холбох, ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах
3. Авто зам, замын байгууламжийн угсралт, өргөтгөх, засварлах болон хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослыг бууруулах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хууль хяналтын байгуулагууд, иргэд, аж ахуйн нэгжүүд хариуцах, ажил, үүрэг, хүрэх түвшинг тодорхой болгон санал санаачилга, оролцоог хангаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд зохион байгуулалттайгаар хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах замаар хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангана.

Тав. Зохион байгуулалт

- 5.1 Зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- 5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцан зохион байгуулна.
- 5.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдааг хангаж, явц үр дүнд нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, ажил эрчимжүүлэн ажиллахын зэрэгцээ орон нутгийн иргэдийн оролцоо, дэмжлэгээр тэдний хөндлөнгийн хяналтыг бий болгох
- 5.4 Аймаг, сумд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.
- 5.5 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилд хоёроос доошгүй удаа тайлагнах.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

- 6.1 Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь “Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх урт болон богино хугацааны хөтөлбөр”, төлөвлөгөөнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх
- 6.2 Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан, шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтан, нийгмийн хэв журам сахиулах олон нийтийн цагдаагийн

ажилтан нараас арга хэмжээгээр ногдуулсан тorguuлийн нийт дүнгийн 40%-тай тэнцэх хэмжээний хөрөнгөөр санхүүжүүлэх

6.3 Хөтөлбөрийг дэмжих олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс өгсөн тусlamж хандив

6.4 Бусад эх үүсвэр

6.5 Хөтөлбөрийг 2018-2020 онд болон цаашид хэрэгжүүлнэ.

Долоо. Дэвшиүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хурээнд:

А.Нэгдүгээр зорилтын хурээнд

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад замын хөдөлгөөнд хамаарал бүхий хууль, тогтоомжийг сургалт, сурталчилгаа, мэдээлэл хэлбэрээр улирал бүр териин болон териин бус байгууллагатай хамтран зохион байгуулна.
 2. Сургалт,сурталчилгааг цахим, мэдээллийн хуудас болон аймаг, орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглан телевизийн нэвтрүүлгийг сар бүр тогтмол зохион байгуулахад хууль сахиулах байгууллагууд болон иргэний зөвлөлтэй хамтран ажиллах
 3. Сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдэгдэхүүн олгох, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал, хэвшлийг бий болгох зорилгоор “Сургуулийн бүс дэх аюулгүйн орчин” төсөл, арга хэмжээг санаачилан хэрэгжүүлэх, түүнд чиглэсэн хөгжөөнт, танин мэдэхүйн болон замын хөдөлгөөний холбогдол бүхий сургалт, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
 4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эхчүүдийг хичээлийн жилийн туршид хуваарь гарган сургууль, цэцэрлэгийн бүсэд эргүүлд татан оролцуулж “Эцэг, эх-зохицуулагч” сэдэвт арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах ажлыг Боловсрол, соёлын газарт даалгаж хэрэгжилтэнд хяналт тавих
 5. “Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх ажилд зохих дэмжлэг үзүүлэх
 6. Нийтийн тээвэр, үйлчилгээ болон такси үйлчилгээг холбогдох стандарт, шаардлагыг хангуулах, хууль бус тээвэрлэлтийг таслан зогсоох, нийтийн тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсоолын байршлыг шинэчлэн тогтоох, өөрчлөх, зохион байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх

Б.Хоёрдугаар зорилтын хүрээнд

1. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг хангуулах чиглэлээр Мөнххаан, Түмэнцогт сумдын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний хяналтын цэг болон улсын чанартай авто зам, зам байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс төлбөр авах цэгүүдийг байгуулж төле камертай болгох
 2. Гэмт хэрэгтэй тэмцэх болон байгалийн давагдашгүй хүчин зүйл, гоц хандварт ёвчин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр суурингийн гаднах авто замуудад цагдаагийн зөөврийн хөдөлгөөнт постын байр /чирэгч/ худалдан авахад дэмжлэг үзүүлэх
 3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдад хөдөлгөөнт эргүүлийн автомашин, мотоцикль, цагдаагийн шалгах багаж буюу бэлэн бус торгуулийн төхөөрөмж, жолоочийн согтуурал шалгагч, тээврийн хэрэгслийн хурд хэмжигч зэрэг орчин үеийн дэвшилт техник, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах төсвийн асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх
 4. Гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, нийгмийн тогтоосон харилцааг зөрчиж буй үйлдлийг таслан зогсоох, илрүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдол бүхий телекамер хяналтын нэгдсэн системийг бий болгох ажлыг хэрэгжүүлэх.

В.Гуравдугаар зорилтын хүрээнд

1. Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэдэд Баруун-Урт сумын авто замуудыг хуваарьлан хариуцуулж цэвэрлэх, бохирдол, цас мөсийг арилгахыг үүрэг болгох
2. Зам тээврийн осол, хэрэг, зөрчил ихээр гардаг зам, /хар/ цэгүүдийн судалгааг сүүлийн 3 жилээр гаргаж, мэргэжлийн байгууллагуудаар судалгаа, шинжилгээ, дүгнэлтийг хийлгэж зам тээврийн осол, хэрэг, зөрчил гарах эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулах
3. Баруун-Урт хотын авто замын сүлжээг сайжруулах /гол зам, уулзварыг өргөтгөх, автомашины зогсоолыг нэмэгдүүлэх, замын гэрлэн дохио, хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэлийг хийх, сайжруулах, замууд дээр өндрийн хязгаар хийх /
4. Авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж хамтран ажиллах
5. Авто замын арчлалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр орон нутгийн өмчит үйлдвэрлэлийн газарт хариуцуулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх
6. Хөдөлгөөний зохион байгуулалт хангалтгүйгээс замын хөдөлгөөний түгжрэл, саатал бий болдог болон хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нэлөөлөхүйц авто зам, уулзвар, гарцуудыг өөрчлөх, шинэчлэх, нэг түвшин, огтолцолтой болгох ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

Г.Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

1. Мотоциклиор үйлдэгдэг авто осол, хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх
2. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай бүх нийтээр тэмцэх аянг өрнүүлж байгууллага, аж ахуйн нэгжүүдийн "Хөдөлмөрийн дотоод журам"-д ажилтан, албан хаагчдыг согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх үүрэг, хариуцлагыг тусгуулах ажлыг зохион байгуулах
3. Төр, төрийн бус байгууллагуудын хүч, дэмжлэгтэйгээр "Бүх нийтийн эргүүл"-ийг улирал бүр зохион байгуулах ажлыг тогтмолжуулах
4. Аймгийн иргэд, Цагдаагийн байгууллагын санал, хүсэлтийг үндэслэн "Олон нийтийн цагдаа"-г гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд томилох асуудлыг шийдвэрлэх
5. Урьдчилан сэргийлэх нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээнүүдэд шаардагдах санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

1. Хөтөлбөрийг аймаг, сум, багийн хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд териийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хамтын ажиллагаа санал, санаачилга, оролцоонд тулгуурлана.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймаг, сумын Засаг дарга, ажлын алба, багийн иргэдийн нийтийн хурал болон багийн дарга нар уялдуулан зохион байгуулж, хяналт тавьна.
3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг батлан, төлөвлөгөөг аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын

зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг гарган, явц үр дүнг хагас, бүтэн жилээр Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

4. Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны чиглэлээр аймаг, орон нутгийн хэмжээнд зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтэнд Цагдаагийн байгууллага болон ГХУСАЗСЗ хамтран хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, хамтран ажиллах

9. Хүрэх үр дүн

1. Зам тээврийн осол, хэрэг буурсан байна.
2. Аймаг, сумдын замын хөдөлгөөний аюулгүй байдлын зохион байгуулалтын ажил сайжирсан байна.
3. Осол, гэмтлийн улмаас нас барсан болон гэмтсэн хүний тоог бууруулсан байна.
4. Хот, сум хоорондын нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа стандарт, шаардлага хангасан, хууль бус тээвэрлэлт таслан зогсоогдсон байна.
5. Иргэд болон цэцэрлэг, сургуулийн насын хүүхдүүдийн замын хөдөлгөөний мэдлэг чадвар хандлага дээшилж, хөдөлгөөний соёл сайжирсан байна.

--оОо--